



**Japan International Cooperation Center (JICE)
JDS PROJECT OFFICE IN MONGOLIA**

Address: Room 201, Mongolia – Japan Center Bldg,
University Ave, Sukhbaatar district, C.P.O Box 917 Ulaanbaatar13,
TEL: 327052; FAX/TEL: 326815

Date: 09.07.2020

Our Reg. No. 20-9-1

Ulaanbaatar city

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ
ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗАРТ**

JDS хөтөлбөрийн элсэлтэнд урих тухай

“Хүний Нөөцийг Хөгжүүлэх JDS Тэтгэлэгт Хөтөлбөр” нь Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар хэрэгжигдэж буй төрийн албан хаагчдыг Япон улсын их дээд сургуулийн магистр, докторын түвшинд суралцуулдаг тэтгэлэгт хөтөлбөр юм.

Тус хөтөлбөр нь 2020 оны 8-р сарын 31-ний өдрөөс докторын 5 дахь элсэлтээ, мөн магистрын 20 дахь элсэлтээ зарласан бөгөөд Япон улсад суралцах хүсэлтэй салбарын албан хаагчдад мэдээлэл хүргэж, сонгон шалгаруулалтанд оролцуулна уу.

Мөн JDS хөтөлбөрийн ерөнхий мэдээлэл, сонгон шалгаруулалт, материал бүрдүүлэлт, судалгааны төлөвлөгөө боловсруулах тухай нээлттэй семинарыг дараах хуваарийн дагуу цахимаар зохион байгуулах тул тус хөтөлбөрийн тухай мэдээллийг боломжтой бол вэб болон фэйсбүүк хуудаснаа, мөн дотоод сүлжээндээ байрлуулж өгнө үү.

- | | |
|---|----------------------------------|
| ① 2020 оны 9-р сарын 14, 18:30-20:00 цагт | ② 9-р сарын 19, 11:00-12:30 цагт |
| ③ 9-р сарын 26, 11:00-12:30 цагт | ④ 10-р сарын 2, 18:30-20:00 цагт |

Мөн суралцах чиглэлийг хавсралт 1-т харуулсан байгаа тул эдгээр чиглэлээр суралцах боломжтой дэмжиж буй албан хаагчдын нэрсийн жагсаалтыг хавсралт 4 дээр гаргаж өгнө үү.

Дэлгэрэнгүй мэдээллийг дараах цахим хуудаснаас харахыг хүсье.
<http://jds-scholarship.org/country/mongolia/apply.html>

Хавсралт: 4 хуудастай.

Хүндэтгэсэн

JICE JDS Монгол дахь Төслийн Оффис

Улс хариуцсан мэргэжилтэн

永澤 彩

НАГАСАВА Аяа





JDS ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДАХ
БАЙГУУЛЛАГУУДАД

МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Бага тойруу 44, Засгийн газрын III байр,
Утас: 26-22-27, Факс: 263727
И-мэйл: info@mes.gov.mn, Веб сайт: www.mes.gov.mn

2020.09.04 № 10/852
танай _____-ны № _____-т

Хөтөлбөрийн бүртгэл эхлүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газар нь Япон Улсын Засгийн газартай хамтран 2001 оноос хойш "Хүний нөөцийг хөгжүүлэх JDS тэтгэлэгт хөтөлбөр"-ийг амжилттай хэрэгжүүлж байна. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд нийт 360 иргэн(энэ жил явах оюутнууд тоонд орсон)-ийг Японы их, дээд сургуулиудын магистр түвшний хөтөлбөрт, 8 иргэнийг докторын түвшний хөтөлбөрт суралцуулахаар илгээсэн. Одоогийн байдлаар нийт илгээсэн иргэдийн 303 нь сургуулиа амжилттай төгсөж, эх орондоо сурсан чиглэлээрээ үр бүтээлтэй ажиллаж байна.

2020 оны 2 дугаар сарын 7-ны өдөр Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газрын төлөөллөөс бүрдсэн хамтын ажиллагааны урьдчилсан судалгааны баг хэлэлцээр байгуулан, 2020-2023 онд хүлээн авах хөтөлбөрийн чиглэл, хамрагдах хүрээ (хавсралт 1)-г шинээр тодорхойлсон. 2020 оны 8 дугаар сарын 26-ны өдөр Удирдах Зөвлөлөөс 2020 оны хөтөлбөрийн сонгон шалгаруулалтад баримтлах ерөнхий зарчмыг баталж, энэ жилээс эхлэн Монгол улсын төрийн албан хаагчдыг чадавхжуулах, Монгол Улсын хөгжилд хувь нэмэр оруулах зорилгоор зөвхөн төрийн жинхэнэ албан хаагчид болон Монголбанк, Монгол улсын хөгжлийн банкны албан хаагчдыг хамруулахаар шийдвэрлэв.

Иймд Япон улсад суралцах хүсэлтэй яамны болон салбар (харьяа агентлагууд)-ын төрийн жинхэнэ албан хаагчдад мэдээллийг өргөнөөр хүргэж, сонгон шалгаруулалтад оролцуулна уу.

Тэтгэлэгт хөтөлбөрийн бүртгэл 2020 оны 8 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэж, магистрын бүртгэл 10 дугаар сарын 28-ны өдөр, докторын бүртгэл 12 дугаар сарын 4-ний өдөр дуусах болно. Хөтөлбөрийн өргөдөл гаргачдад тавигдах шаардлагыг хавсралт 2-оос үзнэ үү.

Бусад дэлгэрэнгүй мэдээллийг JICE JDS Монгол дахь Төслийн оффисын утсаар (327052, 326815) холбогдож лавлана уу.

Хавсралт: 3 хуудас

ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



ДАРДИ

14206 0645

Хүний Нөөцийг Хөгжүүлэх JDS Тэтгэлэгт Хөтөлбөрийн хүрээнд дэвшигдэж буй салбар чиглэлүүд (2020-2023)

Дэд Хөтөлбөр (JDS зорилготой тэргүүлэх чиглэл)	Бүрэлдэхүүн хэсэг (JDS зорилготой хөгжлийн асуудал)	Дэд бүрэлдэхүүн хэсэг	Хүлээн авах хүний тоо*	Боломжит судалгааны сэдвүүд / Суралцах чиглэл* (төсөл)	Зорилготой элсэгч	Хүлээн авах их сургууль	
1. Макро эдийн засгийн зрүүл үйл ажиллагаа ба засаглалыг бэхжүүлэх	1-1 Төрийн санхүүгийн удирдлагын чадварыг сайжруулах	1-1-1 Төрийн санхүүгийн удирдлага	2	Тогтвортой хөгжлийн бодлого Хөгжлийн эдийн засаг Макро эдийн засгийн төлөвлөлт Төрийн санхүүгийн менежмент Төрийн хөрөнгө оруулалтын бодлого Дотоод аудит Олон улсын татварын зохицуулалт Төрийн өрийн менежмент Хөрөнгийн татвар	Бүх төрийн хонхонз албан хаагч болон Монгол банк болон Монгол улсын хөгжлийн банкны албан хаагчид	Сайтамагийн Их Сургууль Хүмүүнлэг, нийгмийн ухаан судлалын тэнхим	
		1-1-2 Төрийн захиргаа	2	Нийгмийн халамжийн удирдлага Нийгмийн аюулгүй байдлын удирдлага Эрүүл мэндийн бодлого Хөдөөгийн хөгжил Бүсчилсэн хөгжил Хүн амын бодлого/ Хотын төвлөрлийг сааруулах бодлого Татварын удирдлага Олон улсын боловсролын харьцуулсан судалгаа Е-засаглал Төрийн худалдан авах ажиллагааны бодлого		Мэйжигийн Их Сургууль Засаглал судлалын тэнхим	
	1-2 Эрчимтэй зах зээлийн эдийн засгийг бүрдүүлэхэд чиглэсэн дэмжлэг	1-2-1 Санхүүгийн бодлого, хөрөнгийн зах зээлийн бодлого	2	Санхүүгийн бодлого Хөрөнгийн зах зээлийн бодлого Үнэс цаас, бондын зах зээлийг сэргээх Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх бодлого Дижитал зах зээлийн бодлого болон менежмент		Олон Улсын Их Сургууль (IUJ) Олон улсын харилцааны тэнхим	
		1-2-2 Бизнес, эдийн засгийн эрх зүйн тогтолцоо	1	Бизнес, эдийн засгийн эрх зүйн тогтолцоо Олон улсын корпорацийн гэрээ байгуулах тухай хууль эрхзүйн хэлэлцээр Эвлэрүүлэн зуучлал ба бусад маргааныг хянан шийдвэрлэх менежмент Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль Өрсөлдөөний тухай хууль Олон улсын санхүүгийн хууль, журам		Кюүшүгийн Их Сургууль Хуулийн тэнхим	
2. Хүрээлэн буй орчинтой зохицсон эдийн засгийн тэнцвэртэй өсөлтийг хангах	2-1 Аж үйлдвэрийн бодлого ба бизнесийн удирдлага		4	Аж үйлдвэрийн бодлого Хөдөө аж ахуйн бодлого Бизнесийн удирдлага болон санхүү ЖДҮ-ийн хөгжил Орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих Тогтвортой хөгжлийн зорилгуудын хяналт	Олон Улсын Их Сургууль (IUJ) Олон улсын менежментийн тэнхим (2 квот)		
				2-2 Өсөлтийг хангахуйц өндөр чанартай дэд бүтцийг байгуулах	2	Хотын бодлого Хот / бүс нутгийн төлөвлөлт Тээврийн төлөвлөлт Төр, хувийн хэвшлийн түншлэл Хотын хөгжлийн төслийн менежмент Геодезийн мэдээллийн дүн шинжилгээ Бохир ус цэвэрлэх төлөвлөгөө, менежмент Логистикийн менежментийн систем Нэгдсэн тээвэр	Нагаока Технологийн Их Сургууль Иргэний барилга, байгаль орчны инженерчлэлийн тэнхим
						2-3 Хотын хүрээлэн буй орчны менежментийг сайжруулах	2
Жилд хүлээн авах нийт хүний тоо			15				

*Бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн элсэгчийн тоог хуваарилах, судалгааны сэдэв, зорилготой байгууллагыг урьдчилсан судалгаагаар нэгтгэн боловсруулна.

Магистрын хөтөлбөрийн элсэгчдэд тавигдах шаардлага

Иргэншил	Монгол улсын иргэн байх
Нас	2021 оны 4-р сарын 1-ний байдлаар 25-39 настай байх (1981 оны 4-р сарын 2-оос 1996 оны 4-р сарын 1-ний хооронд төрсөн байх)
Боловсрол	<ul style="list-style-type: none"> • Монголын болон гадаадын магадлан итгэмжлэгдсэн их дээд сургуульд бакалаврын зэрэг эзэмшсэн байх. • Бүрэлдэхүүн хэсэг 1-2-2 Кюүшүгийн Их Сургуулийн Хуулийн тэнхимд өргөдөл гаргах элсэгч нь хуулийн чиглэлээр бакалаврын зэрэг хамгаалсан байх.
Ажил байдал	<ul style="list-style-type: none"> • Дараах хүмүүс хөтөлбөрт хамрагдах боломжтой: 1) Төрийн жинхэнэ албан хаагч (Төрийн тусгай болон захиргааны албан хаагч) 2) Монгол банк болон Монголын хөгжлийн банкны ажилтан байх.
Ажлын туршлага	<ul style="list-style-type: none"> • Өргөдлийн маягт хүлээн авах эцсийн өдрийн байдлаар холбогдох байгууллагад 2-с дээш жил ажилласан туршлагатай байх.
Англи хэлний мэдлэг	<ul style="list-style-type: none"> • Магистрын түвшинд судалгаа хийхэд шаардагдах хэмжээний англи хэлний чадвартай байх. • TOEFL iBT 60 (ITP 500), IELTS 5.5 дээш оноотой байвал давуу талтай.
Эрүүл мэндийн байдал	<p>Бие махбодь, сэтгэцийн хувьд эрүүл байх.</p> <p>* JDS хөтөлбөрийн зүгээс зохион байгуулах эрүүл мэндийн үзлэгт хамрагдаагүй тохиолдолд сонгон шалгаруулалтаас хасна.</p>
Хамрагдах боломжгүй хүмүүс	<p>Дараах хүмүүс хөтөлбөрт хамрагдах боломжгүй. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Одоогийн байдлаар тэтгэлэгт хамрагдаагүй, цаашид өөр тэтгэлэгт хамрагдахаар төлөвлөөгүй байх. • Гадаад орны тэтгэлгээр магистр болон түүнээс дээш зэрэг горилоогүй байх. • Цэргийн зэрэг цолтой албан хаагч, хугацаат цэргийн албанд харьяалалтай хүн, цэргийн албанаас түр хугацаагаар чөлөөлөгдсөн хүн.
Бусад	<ul style="list-style-type: none"> • Сүүлийн сонгон шалгаруулалтад оролцохдоо "Монгол улсдаа төгсөөд ирэхэд нь байгууллагадаа эргэн ажиллуулах тухай" баталгааны бичгийг байгууллагын удирдлагаасаа авч ирүүлэх шаардлагатай. • Тус тэтгэлэгээр суралцахаар болсон тэнцэгчид нь "Амлалтын бичиг", "Баталгаажуулах бичиг"-ийг бөглөн, ирүүлэх шаардлагатай. • JDS төгсөгчид нь төгсөж ирээд, хоёроос доошгүй жилийн хугацаанд амлалтын бичиг дэхь үүргээ биелүүлж, өмнө нь ажиллаж байсан байгууллагадаа ажиллаж, Монгол Улсаа хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулна гэж заасан байна. • JDS оюутнууд нь хөтөлбөрийн зорилгыг сайтар ухамсарлан суралцаж, төгсөж ирээд эх орныхоо хөгжилд хувь нэмрээ оруулах чин хүсэл эрмэлзэлтэй байх.

Докторын хөтөлбөрийн элсэгчдэд тавигдах шаардага

Иргэншил	Монгол улсын иргэн байх
Нас	2021 оны 4-р сарын 1-ний байдлаар 45 болон түүнээс доош настай байх (1975 оны 4-р сарын 2-ны өдрөөс хойш төрсөн байх)
Боловсрол	JDS хөтөлбөрийн төгсөгч байх эсвэл Японд магистрын зэрэг хамгаалсан байх (Зарчмын хувьд магистрын зэрэг хамгаалсан сургуульдаа элсэх)
Ажил байдал	Дараах хүмүүс хөтөлбөрт хамрагдах боломжтой: 1) Төрийн жинхэнэ албан хаагч байх (Төрийн тусгай болон захиргааны албан хаагч) 2) Монгол банк болон Монголын хөгжлийн банкны ажилтан байх
Ажлын туршлага	Японд магистр төгссөнөөс хойш дээр дурьдсан төрийн байгууллагад үндсэн албан хаагчаар 2-оос дээш жил ажилласан байх
Эрүүл мэндийн байдал	Бие махбодь, сэтгэцийн хувьд эрүүл байх. *JDS хөтөлбөрийн зүгээс зохион байгуулах эрүүл мэндийн үзлэгт хамрагдаагүй тохиолдолд сонгон шалгаруулалтаас хасна.
Хамрагдах боломжгүй хүмүүс	Дараах хүмүүс хөтөлбөрт хамрагдах боломжгүй. Үүнд: • Одоогийн байдлаар тэтгэлэгт хамрагдаагүй, цаашид өөр тэтгэлэгт хамрагдахаар төлөвлөөгүй байх. • Гадаад орны тэтгэлгээр докторын зэрэг горилоогүй байх. • Цэргийн зэрэг цолтой албан хаагч, хугацаат цэргийн албанд харьяалалтай хүн, цэргийн албанаас түр хугацаагаар чөлөөлөгдсөн хүн.
Бусад	<ul style="list-style-type: none"> • Харьяа байгууллагын удирдах албан тушаалтнаас дараах бичиг баримтыг авч ирүүлэх шаардлагатай (Нэр дэвшүүлэх тодорхойлолт, өргөдөл гаргагчийн тодорхойлолт. Өргөдөл гаргагчийн тодорхойлолтонд ажил байдлын үнэлгээ болон судалгааны ажлын сэдэв нь элсэгчийн цаашдын ололт амжилт, байгууллагынхаа хөгжилд хэрхэн нөлөөлж чадах эсэхийг дурьдна.) • Элсэх хүсэлтэй их сургуулийн удирдагч багшаас тодорхойлолт бичүүлж авах шаардлагатай (Удирдагч багш судалгааны ажлын төлөвлөгөөг хянасан байх) • Дэд хөтөлбөр, бүрэлдэхүүн хэсгүүдийн хүрээнд дурьдсан Монгол Улсын хөгжлийн асуудалтай холбоотой судалгааны ажил бичиг шаардлагатай. • Зарчмын хувьд 3 жилийн хугацаанд докторын зэргээ хамгаалах ёстой. Хэрвээ докторантур төгсөх нь тодорхой болсон тохиолдолд хагас жилээр сунгах боломжтой • Тус тэтгэлэгээр суралцахаар болсон тэнцэгч "Амлалтын бичиг"-ийг бөглөн, ирүүлэх шаардлагатай.

The Project for Human Resource Development Scholarship by Japanese Grant Aid in Mongolia 2020

LIST of POSSIBLE APPLICANTS for JDS 1st Batch (Selection year 2020)

Name of Organization: _____

Date of Submission: _____

Deadline of Submission: 2 October, 2020

To be sent to: jds.mongolia@jice.org

No.	Full Name of Applicant	Section / Division / Department	Current Position	Age	Email	Phone number	Component	Remarks
Ex.	Ms. OYUN Boldbaatar	Department of Monitoring and Evaluation	Chief Officer	30	oyu@yahoo.com	99714085	1-1-1	
1								
2								
3								
4								
5								
6								
7								
8								
9								
10								
11								
12								
13								
14								
15								

ATTENTION - Please, read this notice at the nomination of possible applicants

Please endorse applicants who meet the following requirements:

- Between 25 and 39 years old (inclusive) as of April 1 in 2021. (Born on/after April 2, 1981 and born on/before April 1, 1996)
- Possess a Bachelor Degree from universities authorized by the Government of Mongolia or other countries.
- Currently employed with permanent status.
- 1) Core Civil service (Administrative service <TZ>/Special service <TT>) of central/regional Mongolian government organizations
- 2) Officers of Bank of Mongolia/Development Bank of Mongolia
- Have at least 2 (two) years of full-time work experience in the job category stated above at the time of application.
- Not to go against internal regulations regarding overseas education.

※Please attach the internal regulations of your organization regarding overseas education.

I certify that those applicants meet the above-mentioned requirements.

Job Title: _____

Printed Name: _____

Signature: _____

Contact Number: _____
(Office / Mobile)

Thank you for your cooperation!
JICE JDS Project Office in Mongolia